ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/232 Улаанбаатар хот

"Иргэний нисэхийн үндэсний төв"
ТӨХХК-ийн галын аюулгүй байдлын
дотоод дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Галын аюулгүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.8.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн салбар, нэгжийн хэмжээнд дагаж мөрдөх Галын аюулгүй байдлын дотоод дүрмийг нэгдүгээр, галын аюулгүй байдлын хяналтын хуудасны маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Галын аюулгүй байдлын дотоод дүрмийг "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн салбар, нэгжүүд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар (П.Гантөгс)-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

1725 04 1426

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн
гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны
өдрийн А/232 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДОТООД ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн салбар, нэгжийн галын аюулгүйн байдлыг тухайн нэгжийн дарга шууд хариуцаж, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлж, тухайн салбар, нэгжийн нөхцөл байдалд уялдуулан галын хэсэг, бүлэг, сайн дурын бүлгэм, ажилтныг томилж, галын аюулгүй байдлын журам батлуулж, гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, салбар нэгжийн хэмжээнд үндсэн болон түр, гэрээт, дагалдан, туршилтаар ажиллаж байгаа ажилтанд мөрдүүлж, хэвшүүлэн, нийт ажилтнууддаа жил тутам гамшиг осол, галын аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх, өөрийгөө болон бусдыг аврах, анхан шатны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх, дадлага сургалтыг дотооддоо болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулна.

1.2.Энэхүү дотоод дүрмийн хэрэгжилтэд салбар, нэгжийн дарга, орон нутгийн нисэх буудлын дарга, дотоод хяналтын нэгж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан мөн хавсран гүйцэтгэж байгаа ажилтнууд хяналт тавина.

Галын аюулгүй байдлын дотоод дүрмийн үндсэн зарчим нь Галын аюулгүйн байдлын тухай хууль, Архивын тухай хууль тогтоомж, Музейн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”, Барилга байгууламжийн галын аюулгүйн байдлын дүрэм БНбД 21-01-02, MNS 5566:2020 стандарт, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулах, заавар зааварчилгаа зэргийг мөрдөж ажиллах замаар хэрэгжинэ.

Хоёр. Удирдлага

Салбар, нэгжийн удирдлага нь гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах, гал түймрийн хяналтыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, бэлэн байдлыг хангуулна.

2.1.Барилга байгууламжийг өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, барилгын дулаалгын хавтан суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах, галын аюултай материалд хүний амьсгал боогдуулах хорт бодис ялгаруулах шинж чанарыг мэргэжлийн байгууллагаар заавал “Дүгнэлт” гаргуулсан байна.

2.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7-д заасан "Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх" үүргийнхээ дагуу Галын аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан ажлын чиг үүргийн хүрээнд тавьсан шаардлагыг байгууллагын нийт ажилтан, гэрээгээр ажиллаж байгаа болон дадлагын оюутан, зочид үүрэг хариуцлага хүлээж шууд биелүүлэх үүрэгтэй.

2.3.Үйлдвэрлэлийн бүх машин, механизм, тоног төхөөрөмж, даралтат сав, шугам хоолой, цахилгаан болон зөөх, өргөх, тээвэрлэх хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх заавар, зааварчилгаатай байна.

2.4.Салбар, нэгж нь бүх машин механизм, цахилгаан тоноглол, даралтат сав, насос, шугам хоолой, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, тэмдэг тэмдэглэгээ, дохио санамж, галын аюулгүй байдлын зураг схем нь Монгол хэл дээр бичигдсэн байна.

2.5.Салбар, нэгжүүд ашиглаж байгаа цахилгаан тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байхаас гадна угсралтын зураг схемтэй, газардуулгатай, газардуулгын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

2.6.Химийн хортой болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх, цацраг, биологийн идэвхт бодисууд түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч, хадгалалт ашиглалтын журамтай байна.

Гурав. Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлагууд

3.1.Гамшиг осол, гал түймрийн үед өрөө, тасалгаанаас гадагш гарах гарц (хаалга) шат, хонгилыг заасан ердийн болон тэжээлийн давхар эх үүсвэртэй гэрэлтэгч тэмдэг тэмдэглэгээг өдөр шөнийн аль ч үед ажиллаж байхаар ажилчдад ил тод харагдахуйц газарт байрлуулна. Мөн аваарын үед зарлан мэдээлэх систем, дуут дохио, чанга яригчтай байна.

3.2.Болзошгүй осол, гал түймрийн үед өрөө, тасалгаанаас гарах хамгийн дөт замыг заасан нүүлгэн шилжүүлэлтийн аврах зам гарцын бүдүүвчийг харагдахуйц газар байрлуулна.

3.3.Цахилгаантай хүчдэлтэй холбоотой ажлуудаа холбогдох албанаас ачаалал тэнцвэржүүлэх шалгалт хийлгэж дүгнэлт гаргуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд машин тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг ашиглах явцад гаднын нөлөөллөөс хамгаалах, хоёр өөр төрлийн утсаар холболт хийхгүй байх, богино холбоо, хэт ачаалал, шилжилтийн эсэргүүцлийн улмаас гал түймэр гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хуваарилах самбар, залгаж салгах хэрэгслийн хамгаалалт нь орчны нөхцөлд тохирсон байх, тусгайлсан хайрцагтай байх, гэмтэлтэй залгуур, үзүүр нь ил задгай дамжуулагч утас, цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглахгүй байх, шинээр суурилуулах цахилгаан тоног төхөөрөмжүүдэд газардуулга хийж, аюулгүй ажиллагааны санамж байрлуулна.

3.4.Хоол үйлдвэрлэлийн өрөөнд агааржуулалтын систем (вентилятор) суурилуулах, хийн түлшний тоног төхөөрөмжийг зааврын дагуу ашиглах, ямар нэгэн гэмтэл илэрвэл холбогдох албанд хандаж, үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож зөрчлийг арилгуулсны дараа үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зориулалтын бус ажлын байранд хоол хийхгүй байна.

3.5.Аянга зайлуулах төхөөрөмжид жил бүр борооны улирал эхлэхээс өмнө үзлэг шалгалт хийж, шаардлагатай бол Оношилгоо хэмжил зүйн лабораториор дүгнэлт гаргуулан, засвар үйлчилгээ хийлгэнэ.

3.6.Зайлшгүй шаардлагаар өргөтгөл, засварын ажил хийх үед галтай харьцах гагнуур хийх нөхцөлд гал түймэр гарахаас урьдчилан сэргийлж үл шатах материалаар хамгаалалт хийх, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл бэлдүүлэх зэрэг болзошгүй осол, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хийсний дараа гүйцэтгэлд хяналт тавина.

3.7.Агуулахад дотор бараа материалыг хана болон таазнаас 0,6м-ээс багагүй зориулалтын тавиур ашиглан хураах, цахилгаан хангамжийн ашиглалтын галын аюулгүй байдлыг бүрэн хангах, гэрэлтүүлэгт тэсрэлтээс хамгаалагдсан бүрхүүл хийх, мөн тухайн салбар, нэгжийнхээ гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг норм, нормативын дагуу байршуулна.

3.8.Газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах зэрэг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, "Галын эрсдэлийн үнэлгээ хийлгэх", зөвлөгөө авах, эрсдэлийг бууруулахад авч хэрэгжүүлэх нөөц бүрдүүлэх холбогдох даатгалд хамрагдах.

Дөрөв. Болзошгүй гал түймрийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.Гал түймрийг анх илрүүлсэн, харсан хүн нь 101, 105 дугаарын утас, "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал /цаашид "БУОУНБ" гэх/-ын Аврах гал унтраах албаны 7128-1625 дугаар утсанд мэдэгдэх, мэргэжлийн ажилтнаар цахилгааны хэлхээг тэжээлээс салгуулах арга хэмжээ авч, аваарын дуут дохиог ажиллуулна.

Алба нэгжийн удирдлага нь хууль, дүрэм, журмын хүрээнд эрх бүхий албан тушаалтанд гаргасан гал түймрийн талаар үнэн зөв мэдээ мэдээллээр хангана.

4.2.Гал унтраах зориулалтын тээврийн хэрэгслүүд нь БУОУНБ-ын хамгаалалтын хашааны А-3, В8-р постоор нэвтэрч тухайн газарт хүрэлцэн очно.

Тухайн өдрийн ерөнхий зохицуулагч нь Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Аврах, гал түймэр унтраах 14, 30, 65 дугаар ангиудын тээврийн хэрэгсэлтэй холбогдон мэдээллээр ханган, БУОУНБ, орон нутгийн нисэх буудлууд нь тухайн нутаг дэвсгэрийн Онцгой байдлын ангитай хамтран ажиллах гэрээ байгуулна.

4.3.Салбар, нэгжүүдийн ажлын байр, өрөө тасалгаа агуулахад гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулахдаа Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2020 стандартыг баримтлах бөгөөд түүнд зориулагдсан хөрөнгийг салбар, нэгжийн удирдлага өөрсдийн санхүүгийн төлөвлөгөөнд тусган саналыг хүргүүлнэ.

4.4.Гал унтраах анги иртэл галын бүлгийн болон сайн дурын бүлгэмийн гишүүд, гал унтраах, аврах, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гал унтраах ангийг угтан авч үүссэн нөхцөл байдлыг танилцуулж хамтран ажиллана.

Тав. Хориглох зүйл

5.1.Барилга байгууламж шинээр барих, төлөвлөхдөө гал унтраах автомат систем, галын дохиоллын систем, галын дотуур усан хангамжийн систем болон гамшгийн аюулыг мэдээлэх зарлан мэдээлэх системтэй хамт төлөвлөсөн байна.

Салбар, нэгжид харьяалагдах барилга байгууламжийн өрөө тасалгаанд зураг төслийн дагуу засвар хийх ба мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн барилгын хийц бүтээц, цахилгаан шугам сүлжээг өөрчлөхийг хатуу хориглоно.

5.2.Цахилгаан зарцуулалт өндөртэй хэрэгсэл тоног төхөөрөмжийг ашиглах, ил гал гаргах, гэмтэлтэй цахилгаан утас болон цахилгааны уртасгагч хэрэглэхийг хориглоно.

5.3.Гал унтраагуур, шингэрүүлсэн шатдаг хийн баллоныг зөөвөрлөх үедээ газраар чирэх, шидэх, өнхрүүлэх, хатуу зүйлээр цохихыг хориглоно.

5.4.Хөлдсөн шугам хоолойг ил галаар гэсгээхийг хориглоно.

5.5.Авралтын зам гарц, хаалганд хүрэх замыг хааж эд зүйлс, бараа материал хураах, байрлуулахыг хориглоно.

5.6.Шатахуун хангамж, шатахуун түгээх станц болон хориотой бүсийн ажлын байранд чүдэнз, асаагуур авч орох, ил гал гаргахыг хориглоно.

5.7."Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн салбар, нэгжийн өрөө тасалгаанд лаа болон ил гал асаах, арц, хүж уугиулах, хамгаалагдсан бүсэд шар өвс шатаах, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт утаат тамхи татахыг хориглоно.

5.8.Галын аюулгүй байдлын сургалтад бүх ажилчдаа бүрэн хамруулна. Сургалтад хамрагдаагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байна.

Зургаа. Хариуцлага

6.1.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, барилгын норм дүрэм, стандарт зөрчсөн, зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, барилгын норм дүрэм, стандартыг зөрчсөн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

Долоо. Шагнал урамшуулал

7.1.Ажиллах явцдаа галын аюулгүй байдалтай холбоотой ноцтой эрсдэл илрүүлж, арилгуулсан, аюулын талаар үнэн зөв мэдээлэл өгч, болзошгүй гал түймэр, эд материалын хохирлоос урьдчилан сэргийлсэн, гарсан гал түймрийг унтраах ажиллагаанд санаачилгатай оролцсон ажилтныг удирдах ажилтны үнэлгээ, ажлын тодорхойлолт зэргийг үндэслэн шагнаж урамшуулна.

---ooOoo---

"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн
гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны
өдрийн А/232 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Барилга, байгууламжийн нэр					
	Шалгалтыг гүйцэтгэсэн албан тушаалын нэр					
1	Галын сайн дурын бүлгэм байгуулсан эсэх					
2	Галын аюулгүй байдлын журамтай эсэх					
3	Барилга байгууламжид гамшиг осол, гал түймрийн үед хүний амь нас, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх авралтын зам гарцын схем зургийг байрлуулсан эсэх					
4	Гал унтраах шуурхай төлөвлөгөөтэй эсэх					
5	Галын зардлыг төсөвтөө суулгасан, нөөцийн нөхөн хангалт хийсэн эсэх					
6	Үзүүлэлтүүд	Иж бүрдэл	Гал унтраагуур төрөл 2кг-35кг			
7	Гал унтраагуур	Барилгад автомат гал унтраагуур байрлуулсан эсэх				
		Зөөврийн гал унтраагуур байрлуулсан эсэх				
		Гал унтраагуурын тэмдэглэгээ, хяналтын карттай эсэх				
8	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж	Галын дохиоллын систем төлөвлөгдсөн эсэх				
		Удирдлагын самбар				
		Утаа мэдрэгч				
		Дулаан мэдрэгч				
		Барилгын авралтын гарцын дээр аваарын гэрэл болон Exit гэрэлтүүлэг байрлуулсан эсэх				
9	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	Хүрз				
		Галын дэгээ				
		Хувин				
		Сүх				
		Элстэй сав				
		Хөрөө				
		Галын хор 2 кг-35 кг				
		Бөмбөлгөн галын унтраагуур				
		Цохиур				
		Каска малгай				
		Гал унтраах бүтээлэг				
		Тармуур				
		Гадна талд байрлуулсан галын унтраагуур нь уут хийгдсэн эсэх				
		Эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрдэл				
		Галын бээлий				
		Лоом				
		Барилга байгууламжид гамшгаас урьдчилан сэргийлэх болон гал түймрээс урьдчилан сэргийлэх самбар байрлуулсан эсэх				

10	Галын гидрант систем	Галын дотуур усан хангамжийн систем /ГК-галын хоолой, хошуу, гайк иж бүрдэл бүрэн эсэх/, хэвийн ажиллагаатай эсэх	
		Галын хайрцаг	
		Галын хоолой	
		Галын хошуу	
		Гайк, тотго	
		Галын дотуур усан хангамжийн систем /ГК/ тэмдэглэгээг байрлуулсан эсэх	

---ooOoo---